



НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2011 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 5.2.2, 5.2.4, 7.6, 12.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх журам"-ыг хавсралтын ёсоор шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан журмыг мөрдөн ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Ч.Алтанхуяг/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс /Ч.Мөнхдэлгэр/, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ш.Мөнхцэрэн/-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн 2009 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 09 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н.ХҮРЭЛБААТАР



Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн  
2011 оны 02 дугаар сарын 27-ны  
өдрийн 03 зөвлөл  
УХА 0117

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь даатгуулагчдад эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, стандарт хангасан эмийн сангаар дамжуулан эмийн үйлчилгээг даатгуулагчдын эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжлийн түвшинд хүргэх замаар эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад оршино.

1.2. Даатгуулагч Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7.6-д заасны дагуу өрх, сум, багийн эмч /цаашид "эмч" гэх/-ийн бичсэн зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад багтсан эмийг хөнгөлөлттэй үнээр худалдан авах, эмийн сангаас эдгээр эмээр үйлчлэх, нийгмийн даатгалын байгууллага ба эмийн сангийн хоорондын төлбөр, тооцооны харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Эрүүл мэндийн даатгалын сангаас зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад заасан эмийг хөнгөлөлттэй үнээр олгоход Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, эмийн жорын маягт, жор бичилт MNS 5376:2008 стандарт, эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2011 стандарт, Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн 2011 оны 02 тоот тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалт, хөнгөлөх хувь, хэмжээ", энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдөнө.

### Хоёр. Даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх

2.1. Даатгуулагч нь харъяалах өрх, сум, багийн эмчийн бичсэн жороор зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад заасан эмийг нийгмийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан эмийн сангаас хөнгөлөлттэй үнээр авах эрхтэй.

2.2. Даатгуулагч нь эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ бүрэн төлж, эрүүл мэндийн даатгалын гэрчилгээгээ нутаг дэвсгэрийн харъяа нийгмийн даатгалын байгууллагаар, хэрэв аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан бол шимтгэл төлж, тооцоо хийдэг нийгмийн даатгалын байгууллагаар тус тус баталгаажуулсан байна.

2.3. Даатгуулагч нь өрх, сум, багийн эмчийн бичсэн жорын хуудсанд он, сар, өдөр, овог нэр, эрүүл мэндийн даатгалын гэрчилгээ, регистрийн дугаар болон эмнэлэг, эмчийн нэр, түүний хувийн тэмдэг (тамга) зэрэг мэдээлэл бүрэн зөв бичигдсэн эсэхийг хянана.

2.4. Даатгуулагч нь өрх, сум, багийн эмчээсээ эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтын талаарх болон холбогдох бусад мэдээлэл авна.

2.5. Даатгуулагч нь хууль, журам зөрчсөн, шаардлага хангаагүй эмээр үйлчилсэн эмийн сангийн талаар мэргэжлийн хяналтын болон нийгмийн даатгалын байгууллагад хандан мэдээлэл өгч, эрх ашгаа хамгаалуулна.

## Гурав. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жор бичих

3.1. Өрх, сум, багийн эмч нь эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жорыг даатгуулагч өвчний учир тусламж, үйлчилгээ авах шаардлагатай тохиолдолд Монгол Улсын MNS 5376:2008 стандартыг баримтлан бичнэ.

3.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийг энгийн эмийн жорын маягтад бичнэ. Эмийн жорын нэг маягт дээр гурваас илүүгүй нэр төрлийн эмийг эмийн ерөнхий нэршлээр бичнэ. Эмийн жорыг ерөнхий нэршлээр бичээгүй тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэхгүй.

3.3. Тухайн эрүүл мэндийн байгууллага (өрх, сум, багийн эмнэлэг) нь эмчийг эмийн жорын маягтаар хангана.

3.4. Сумын эмнэлгийн эрхлэгч нь багийн бага эмч нарт олгох жорын маягтыг кодлон тодорхой тоо, ширхэгээр хүлээлгэн өгч, улирал бүр тооцоо нийлэн, эмийн жор бичилт, эм олголтод хяналт тавьж ажиллана.

3.5. Эмч нь тухайн өвчин эмгэгийн оношлогоо, эмчилгээний удирдамжийг баримтлан эмийн жорыг нэг удаад 5 хүртэлх хоногийн тунгаар бичих ба уг жор нь бичигдсэн өдрөөс эхлэн 10 хоногийн хугацаанд хүчинтэй.

3.6. Удаан хугацаагаар хэрэглэгдэх эм /уналт таталтын эсрэг, дааврын, цусны даралт, салга өвчин эмчлэх, сэтгэцийн эмгэгт хэрэглэх, чихрийн шижин эмчлэх, бамбай булчирхайн даавар, элэг цусны үйл ажиллагаанд нөлөөлөх болон элэг хамгаалах бэлдмэл гэх зэрэг тэдгээрийг эмчлэх/-ийг 30 хүртэлх хоногийн тунгаар бичиж болох ба уг жор нь бичигдсэн өдрөөс эхлэн мөн 10 хоногийн хугацаанд хүчинтэй.

3.7. Өрх, сум, багийн эмч нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

3.7.1. Эмийн жорын маягтыг асуумжийн дагуу бүрэн гаргацтай бичиж, гарын үсгээр баталгаажуулах /эмчийн код, тэмдэг тод байна/;

3.7.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жоронд хөнгөлөлтөд хамрагдахгүй бусад эмийг бичихгүй байх;

3.7.3. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн талаар даатгуулагчийг тодорхой мэдээллээр хангах.

3.8. Эмийн жорыг батлагдсан маягтаар бичээгүй, эмийн нэр, тун хэмжээг буруу, алдаатай бичсэн, засварласан болон тамга тэмдэг, код, гарын үсэггүй, гаргацгүй бичсэн тохиолдолд жорыг хүчингүйд тооцож эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олгохгүй.

## Дөрөв. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмээр үйлчлэх

4.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмээр үйлчлэх эмийн сан нь “Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2011” стандартыг хангасан байна.

4.2. Нийслэл, аймгийн эрүүл мэндийн газар /цаашид “эрүүл мэндийн газар” гэх/ нь хөнгөлөлттэй эмээр үйлчлэх зөвшөөрөл олгохдоо даатгуулагчид эмийн сангийн

үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх зарчмыг баримтлан сонгон шалгаруулалтаар шийдвэрлэж, хөнгөлөлттэй эмийн үйлчилгээ шинээр үзүүлэх эмийн сангийн жагсаалтыг нийгмийн даатгалын байгууллагад жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан ирүүлнэ.

4.3. Эмийн сан нийгмийн даатгалын байгууллагад дор дурдсан баримт, бичгийг бүрдүүлж ирүүлснээр эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олгоно:

4.3.1. Төлбөрийн нэхэмжлэл;

4.3.2. Даатгуулагчдын овог нэр, регистрийн болон эрүүл мэндийн даатгалын гэрчилгээний дугаар бүхий жагсаалт цахимаар болон цаасаар;

4.3.3. Эмийн жор болон даатгуулагчид олгосон эмийн нэр, тоо хэмжээ, үнийн дүн, даатгуулагчийн өөрөө төлсөн төлбөрийн хэмжээг бар кодын машинаар уншуулсан кассын машины тасалбар /даатгуулагч бүрээр/.

4.4. Эрүүл мэндийн газар нь дор дурдсан үүрэг хүлээнэ. Үүнд:

4.4.1. Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жор бичих эмчийн нэрсийн жагсаалтыг гаргаж, эмч бүрийн кодыг тухайн аймаг, дүүрэг сум, багийн кодын хамт нийгмийн даатгалын байгууллагад ирүүлэх, тухайлбал: аймаг, хотын код 01, дүүрэг, сум, өрхийн код 20, эмчийн код 01 бол тухайн эмчийг "01 20 01" гэж кодлон ирүүлэх;

4.4.2. Эмнэлгийн байгууллагын болон эмчийн хаяг өөрчлөгдсөн тохиолдол бүрт эдгээр өөрчлөлтийн талаар нийгмийн даатгалын байгууллагад тухай бүр нь мэдээлэх;

4.4.3. Энэ журмын 4.4.2-т заасан мэдээллийг өгөөгүйгээс эрүүл мэндийн даатгалын санд учруулсан хохирлыг хариуцах;

4.4.4. Зөвшөөрөл олгосон эмийн сангийн үйл ажиллагааг аттестатчлах ажлыг нийгмийн даатгалын байгууллагатай хамтран хоёр жил тутамд зохион байгуулж, дүнг үндэслэн зөвшөөрлийн хугацааг сунгах, түр түдгэлзүүлэх, цуцлах асуудлыг тухай бүр шийдвэрлэх.

4.5. Эмийн сан дор дурдсан үүрэг хүлээнэ. Үүнд:

4.5.1. Даатгуулагчид чанартай, баталгаатай, зайлшгүй шаардлагатай эмээр үйлчлэх;

4.5.2. Өрх, сум, багийн эмчийн бичсэн жороор үйлчлэх;

4.5.3. Өөрийн хаягийн хэсэгт "Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмээр үйлчилнэ" гэсэн тодотгол болон Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн тогтоолоор баталсан "Даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт, үнэ, хөнгөлөх хувь хэмжээ"-г иргэд, даатгуулагчдад харагдахуйц газар ил, тодоор бичиж байрлуулах;

4.5.4. Эмчийн жороор бичсэн эм нь тухайн ерөнхий нэршлээр байхгүй тохиолдолд худалдааны нэр бүхий эмээр орлуулан олгох;

4.5.5. Эмчийн жоронд бичсэн эмийн оронд өөр нэршлийн эм, тухайн эмийн өөр хэлбэрийг олгохгүй байх; *Төрөлшл*

4.5.6. Эмчийн жоронд бичдсэн эмийн тун тухайн эмийн санд байхгүй бол нэршил болон эмийн хэлбэр нь ижил өөр тунтай эмэнд шилжүүлэн тооцон, олгох;

4.5.7. Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн 2011 оны 02 тоот тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалт"-д багтсан эмийн 90-ээс доошгүй хувийн хангалттай байх;

4.5.8. Жоронд байвал зохих эмчийн код, тэмдэг, овог нэр, онош болон бусад мэдээллийг бүрэн эсэхийг хянаж эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийг даатгуулагчид түргэн шуурхай, чирэгдэлгүй олгож холбогдох мэдээллээр хангах;

4.5.9. Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалт, хөнгөлөх хувь, хэмжээ"-нд заасан эмийн үнийн дээд хязгаараас илүү үнээр даатгуулагчид эм олгохыг хориглох;

4.5.10. Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжлэх төлбөрийн тооцоог ЭМДМ №2 хүснэгтийн дагуу цахим болон цаасан хэлбэрээр, эмийн жор, кассын тасалбарын хамт сар бүрийн 05-ны дотор харъяалагдах нийгмийн даатгалын байгууллагад ирүүлэх.

#### Тав. Нийгмийн даатгалын байгууллагаас эмийн үнийн хөнгөлөлт олгох

5.1. Нийгмийн даатгалын байгууллага нь энэ журмын 4.2-т заасан жагсаалтыг хүлээн аваад эрүүл мэндийн даатгалын сангаас олгох эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын төсвийн төслийг аймаг, нийслэл, дүүргийн даатгуулагчийн тоо, өвчлөлийн байдал, эмийн үнэ, тусламж үйлчилгээний хүртээмж, өмнөх оны санхүүжилтийн гүйцэтгэл, хөнгөлөлттэй эмээр үйлчлэх зөвшөөрөл бүхий эмийн сангийн тоо болон бусад холбогдох үзүүлэлтийг үндэслэн боловсруулж, батлуулна.

5.2. Даатгуулагч нь эмчийн жороор зайлшгүй шаардлагатай эмийг хөнгөлөлттэй үнээр авсан тохиолдолд тухайн эмийн үнийн хөнгөлөлтийг нийгмийн даатгалын байгууллага эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн санд төлнө.

5.3. Нийгмийн даатгалын байгууллага дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

5.3.1. Хөнгөлөлттэй эмээр үйлчлэхээр сонгогдсон эмийн сангуудтай даатгалын гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулан, үр дүнг тооцох;

5.3.2. Эмийн үнийн хөнгөлөлтийн асуудлаар даатгуулагч, эмийн сан, өрх, сум, багийн эмч нарыг мэдээллээр хангах, сурталчлах;

5.3.3. Даатгуулагч, эмийн сан, өрх, сум багийн эмч болон бусад холбогдох байгууллагаас ирүүлсэн санал хүсэлтийг судлан эмийн үнийн хөнгөлөлтөд орох эмийн жагсаалт, үнийн дээд хязгаарыг тогтоох, өөрчлөхөд Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлттэй хамтран ажиллах;

5.3.4. Эмийн сангаас ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэлийг хүлээн авсаны дараа уг нэхэмжлэлийн дүнгийн 70 хувийг эхний удаад шууд, үлдэх хэсгийг холбогдох баримтыг хянан шалгасны дараа төлбөрийн нэхэмжлэл хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор төлөх;

5.3.5. Энэ журмын 5.3.4-т заасан нэхэмжлэлийн гүйцэтгэл эрүүл мэндийн даатгалын сангаас урьдчилан олгосон мөнгөн дүнгээс дутуу байвал уг дүнг дараа сард олгох төлбөрөөс суутган тооцох;

5.3.6. Эмч болон эмийн сангийн үйлчилгээний чанар, хүртээмж, төлбөр тооцоонд тогтмол хяналт тавьж даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах;

5.3.7. Энэхүү журам болон гэрээний хэрэгжилтийн байдлыг хагас жил тутамд дүгнэн, дүнг Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлд танилцуулан үр дүнг тооцож ажиллах.

#### Зургаа. Хариуцлага

6.1. Энэ журмыг зөрчсөн эмч, эмийн сан, нийгмийн даатгалын байгууллага /ажилтан/, даатгуулагч, иргэнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Эмч нь эм бичих шаардлагагүй даатгуулагчид эмийн жор бичиж эмийн сангаас эм авсан, эмийн сан нь хуурамч бичиг баримт бүрдүүлэн эмийн үнийн хөнгөлөлт эдэлсэн нь

ЭМ тухай хууль

тус тус тогтоогдсон бол буруутай эмч болон эмийн санд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.3. Нийгмийн даатгалын байгууллага нь эмийн санд төлөх төлбөрийн хугацааг хожимдуулсан бол уг төлбөрийг нөхөн төлж, хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлбөл зохих төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг эмийн санд төлнө.

6.4. Эмийн сан нь эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, үйлчлүүлсэн даатгуулагчаас нэмэлт төлбөр авсан, хуурамч баримт бичгээр санхүүжилт авсан нь тогтоогдсон, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс гомдол, шүүмжлэл ирүүлсэн тохиолдолд нийгмийн даатгалын байгууллага нь тухайн эмийн сантай байгуулсан даатгалын гэрээг цуцлах, санхүүжилтийг зогсоох хүртэл арга хэмжээ авна.

--- о О о ---